



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг  
Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12  
E-mail: khentii@audit.gov.mn

2018.02.28 № 06/33

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Галшар сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Галшар сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Галшар сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг, хариуцлага**

Галшар сумын Ерөнхий боловсролын сургууль нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

0500414



Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.



ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭРДЭНЭБААТАР





**YAG**  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**ХЭНТИЙ АЙМГИЙН ГАЛШАР СУМЫН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН 2017 ОНЫ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл  
дараах хаягаар харилцана уу:**

ТАГ-ын дарга, Тэргүүлэх аудитор :

Ч.Эрдэнэбаатар

Утас: 70562112 70562147

Аудитын менежер :

Д.Оюунтуяа

Утас: 70562147

**АУДИТЫН ТАЙЛАН**

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Хаяг:

Хэнтий аймаг дахь Төрийн Аудитын

Газар

Хэнтий аймаг

Хэрлэн сум

Сариг баг

Монгол улс

Цахим хуудас:

[www.khentii@audit.gov.mn](http://www.khentii@audit.gov.mn)

“Ай Жэй Эй Эйч Аудит” ХХК

Захирал: Г.Энхмаа

Утас: 99040059 450279



## АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар
11. Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт



## 1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Галшар сумын Ерөнхий боловсролын сургуулийн төсвийн 2017оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд ХЭА-2018/03/-СТА-ХАК-ТШЗ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Хэнтий аймгийн Галшар сумын Ерөнхий боловсролын сургуулийн төсвийн 2017оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, программ хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Хэнтий аймгийн Галшар сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2017 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 12 дугаар сарын 19-нөөс 2018 оны 02 дугаар сарын 25-ны хооронд хийхээр төлөвлөн Ай Жэй Эй Эйч Аудит ХХК-ний аудитор хэрэгжүүлэв. /ЛАБ-СТА-А-9/

Хэнтий аймгийн Галшар сумын Ерөнхий боловсролын сургууль нь төсвийн 2017 оны санхүүгийн тайланг 2018 оны 01 дүгээр сарын 06 -нд Ай Жэй Эй Эйч Аудит ХХК-д ирүүлсэн байна.

Ай Жэй Эй Эйч Аудит ХХК нь аудитыг 2017 оны 12 дугаар сарын 25 наас 2018 оны 02 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 02 дугаар сарын 25-нд Галшар сумын Ерөнхий боловсролын сургуулийн удирдлагад гардуулна.



## 2.Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Хэнтий аймгийн Галшар сумын Ерөнхий боловсролын сургуулийн төсвийн захирагч нь “Төсвийн тухай”, “Төрийн албаны тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай”, “Бага дунд боловсролын тухай”, “Боловсролын тухай”, “Хүүхдийн эрхийн тухай”, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай, “Нийгмийн даатгалын тухай”, “Хувь хүний орлогын албан татварын тухай”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай”, “Хөдөлмөрийн тухай”, Шилэн дансны тухай” хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт нэмж мөрдөх Монгол улсын их хурлын 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн 29 дүгээр тогтоолоор баталсан “Монгол улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” тогтоол батлагдсан байна.

## 3.Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Хэнтий аймгийн Галшар сумын Ерөнхий боловсролын сургуулийн эрхэм зорилго: “Ерөнхий боловсрол эзэмшүүлж, амьдрал хөдөлмөрт тасралтгүй суралцахад бэлтгэнэ” гэж тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.18-д “төсвийн бусад байгууллагын дарга (захирал, эрхлэгч) тухайн байгууллагын төсвийн шууд захирагч байна” гэж заасны дагуу Хэнтий аймгийн Галшар сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал Төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Хэнтий аймгийн Галшар сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2017 оны төсвийг Боловсрол Соёл шинжлэх ухааны яамнаас аймгийн Төрийн сангаар дамжуулан олгож байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгуулагатай холбоотой Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.



Хэнтий аймгийн Галшар сумын Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягад тодорхой тусгасан.

**4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:**

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Хэнтий аймгийн Галшар сумын Ерөнхий боловсролын сургуулийн төсвийн 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа./ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар 7 дансанд 13 аудитын нарийвчилсан горим, сорилыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-А-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад Хэнтий аймгийн Галшар сумын Ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинээр боловсруулж мөрдөөгүй байна.

Хэнтий аймгийн Галшар сумын Ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Хэнтий аймгийн Галшар сумын Ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

**5. Дотоод хяналт:**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Хэнтий аймгийн Галшар сумын Ерөнхий



боловсролын сургуулийн дотоод хяналт эрсдлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт зарим талаар хангалтгүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, түүнийг хэрэгжүүлэхээр гаргасан заавар, журмыг хэрэгжүүлж, нягтлан бодох бүртгэлийн “CTS” програмаар нягтлан бодох бүртгэлээ хөтлөн санхүүгийн тайланг гаргасан нь УСНББОУС-тай нийцсэн байна.

#### **6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:**

2017 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу аймгийн Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Хэнтий аймгийн Галшар сумын Ерөнхий боловсролын сургуулийн төсвийн захирагч нь 2017 онд улсын төсвөөс төсвийн төлөвлөгөөний дагуу 378,979.1 мянган төгрөгийн санхүүжилт авч үйл ажиллагааныхаа зардалд 378,958.7 мянган төгрөгийг зарцуулж 20.4 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Дээд шатны нэмэлт санхүүжилтээр 3,540.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 3,542.9 мянган төгрөг олж 7,073.0 мянган төгрөгийг зарцуулж 9.9 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

#### **7. Шилэн дансны мэдээлэл**

Хэнтий аймгийн Галшар сумын Ерөнхий боловсролын сургуулийн вэб сайтад шилэн дансны талаар [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд 2017 оны төсвийн хуваарь, түүний гүйцэтгэл, санхүүгийн тайлан, дараа жилийн төсвийн төсөл, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ зэрэг мэдээллийг байршуулсан байна.

#### **8. Олж тогтоосон гол эрсдлүүд, түүний үр дагавар:**

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 7 дансанд эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 13 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Үр дагаврыг тодорхойлж чадвал: Тус байгууллага нь холбогдох байгууллагын шийдвэргүй хичээл үйлдвэрлэл, урсгал засварын зардлаас үндсэн хөрөнгө худалдан авсан, түлш халаалт, үдийн цайны зардлаас хичээл үйлдвэрлэл, шатахууны зардалд зарцуулсан байна. Санхүүгийн байдлын тайлангийн бараа материалын дансдын ангилал,



бараа материалын тодруулга хэсгийн дансдын ангилал хоорондоо зөрүүтэй, ангилалыг буруу бүртгэсэн байна. Харилцагч байгууллагуудтай тайлант үеүдэд тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй, ажиллагсдад томилолтын мөнгийг олгохдоо хугацааг хэтрүүлэн, томилолтын тооцооны баримтыг бүрэн хийгээгүй, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг шинэчилж боловсруулаагүй байна. Эдгээр алдаа зөрчил нь санхүүгийн тайлангийн оршин байх, хамааралтай байх, иж бүрэн байх, үнэн зөв байдал, толилуулга ба тодруулга, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлүүдийн шаардлагыг хангахгүй байна.

#### **9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:**

Хэнтий аймгийн Галшар сумын Ерөнхий боловсролын сургуулийн төсвийн 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, орлого, санхүүжилт, авлага, өглөг, зардлын дансдаас цалин, нийгмийн даатгалын шимтгэл, хичээл үйлдвэрлэл, томилолт, хоол, үдийн цай, шуудан холбоо, тэтгэмж зэрэг зардлуудын дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт орлогын 95%, мөнгөн хөрөнгийн 95 %, нийт зардлын 90% , нийт хөрөнгийн 70%-ийг тус тус эзэлж байна.

Аудитаар ҮАГ-аас нэгдсэн журмаар авч байгаа 12 судалгааг гаргуулан авсан. Тайлант хугацаанд 8,532.4 мянган төгрөгийн хөрөнгө худалдаж авсан ба аймгийн Боловсрол соёлын газраас 2,982.6 мянган төгрөгийн сургалтын хэрэглэгдэхүүн ирснийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэсэн байна. Орон нутгийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр 268,000.0 мянган төгрөг хуваарилагдаж дуусаагүй барилга дансанд олон жил бүртгэлтэй явсан 923,548.7 мянган төгрөгийн спорт заал, дотуур байрны барилгын дансыг хааж 1,191,548.7 мянган төгрөгийн байгууламжийг байгууллагын барилга байгууламж, орон сууцны дансанд шилжүүлэн бүртгэсэн байна.

#### **10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:**

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Төлөвлөлтийн үед материаллаг байдлыг 2016 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зарлагын 1% буюу 4,364.0 мянган төгрөгөөр тооцов./ТАБ-СТА-А-4/ Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг дахин тооцож 2017 оны 4-р улирлын орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1% буюу 5,005.9 мянган төгрөгөөр



тогтоов. Аудитын явцад материаллаг бус хэмжээний 4,913.2 мянган төгрөгийн зөрчил илэрч байна.

Материаллаг бус дараах зөрчил илэрсэн байна Үүнд:

1. Холбогдох байгууллагын шийдвэргүй хичээл үйлдвэрлэлийн зардлаас 4,060.4 мянган төгрөгийн, урсгал засварын зардлаас 472.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлд Төрийн өмчид эд хөрөнгө олж авах тухай заахдаа "Төрийн өмчид эд хөрөнгө олж авах гэсэн 1 дүгээр зүйлийн 6.1.3-т эрх бүхий байгууллагын шийдвэрээр худалдан авсан эд хөрөнгө" гэж заасныг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулна" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид төсвийн зардлыг хэмнэх, зардлын зүйлийг хэтрүүлэх, зориулалт бусаар зарцуулахгүй байх талаар зөвлөмж өгөх.

2. Санхүүгийн байдлын тайлангийн бараа материалын дансдын ангилал, бараа материалын тодруулга хэсгийн дансдын ангилал хоорондоо зөрүүтэй, буруу бүртгэсэн нь Сангийн сайдын 2014 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 05 тоот тушаалын 5 дугаар хавсралтаар баталсан балансын дансны жагсаалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн: Цаашид балансын дансны ангилалыг зөв, бүртгэж тайлагнах талаар зөвлөмж өгөх.

3. Харилцагч байгууллагуудтай тооцоо нийлсэн акт үйлдэж баталгаажуулаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн Ерөнхий нягтлан бодогчийн эрх үүргийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулах, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах, 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Цаашид тогтмол харьцдаг байгууллагуудтай стандарт маягаар тооцоо нийлсэн акт үйлдэж баталгаажуулах талаар зөвлөмж өгөх .

4. Тус байгууллага нь тайлант хугацаанд үндсэн хөрөнгийн элэгдлийн ашиглах хугацааг тооцохдоо Засгийн газрын 233-р тогтоолоор баталсан журамд заасныг



баримталсан нь НББ-ийн бодлогын баримт бичгийн шинэчлэн боловсруулаагүй, шаардлага хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Цаашид Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулан мөрдөх зөвлөмж өгөх.

5. Түлш халаалтын зардлаас 62.6 мянган төгрөгийг шатахуунд, үдийн цайны зардлаас 66.2 мянган төгрөгийг хичээл үйлдвэрлэлийн зардалд зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулна” гэсэн заалтуудыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн: Цаашид төсвийг зардлын бүлгийн дүнд багтаан эдийн засгийн ангилалын дагуу хэмнэлттэй, зориулалтын дагуу, зарцуулах зөвлөмж өгөх.

#### **11. Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:**

Хууль, журам, заавар мөрдөөгүйгээс шалтгаалан гарсан 4, 913.2 мянган төгрөгийн зөрчлийг залруулах боломжгүй тул дахин давтахгүй байх зөвлөмж өгөв.

#### **12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал:**

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

#### **13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:**

Хэнтий аймгийн Галшар сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

#### **14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:**

Хэнтий аймгийн Галшар сумын Ерөнхий боловсролын сургуулийн төсвийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар материаллаг бус 4,913.2 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд зөвлөмж өгөв.



**15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:**

Төсвийн захирагчийн төсвийн 2016 оны санхүүгийн тайланд аудит хийгдээгүй итгэл үзүүлсэн байна.

**16. Зөрчилгүй санал дүгнэлт**

Хэнтий аймгийн Галшар сумын Ерөнхий боловсролын сургуулийн төсвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэл болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 11 хуудас, хавсралтууд 18 хуудас, байгууллагын санал 2 хуудсыг тус тус хавсаргав.

**АУДИТЫН ТАЙЛАНГ**

**ХЯНАСАН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР



Ч.ЭРДЭНЭБААТАР ОГНОО: 2018.02.28  
Д. ОЮУНТУЯА ОГНОО:

**БЭЛТГЭСЭН:** АУДИТОР

231714429

СХА0046 904082

Н.УРАНЧИМЭГ ОГНОО: 2018.02.25





**YAG**  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**ХЭНТИЙ АЙМГИЙН ГАЛШАР СУМЫН  
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН  
2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

**МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

**Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:**

Асуудал 1	
Үндсэн хөрөнгийн талаар .....	2
Асуудал 2	
Зардал хооронд шилжүүлж зарцуулсан талаар.....	3
Асуудал 3	
Үндсэн хөрөнгийн элэгдлийн талаар.....	4

**Тэргүүлэх ач холбогдол №2 зүйлс:**

Асуудал 1	
Санхүүгийн байдлын тайлангийн талаар .....	5
Асуудал 2	
Авлага, өглөгийн талаар .....	6

**2018 оны 2 дугаар сар**



## Менежментийн захидал

Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Хэнтий аймгийн Галшар сумын Ерөнхий боловсролын сургуулийн удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Хэнтий аймгийн Галшар сумын Ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Зөвлөмжийн хэрэгжилтийн тайлан, албан тоотыг 2018 оны 6 дугаар сарын 20-ны дотор Хэнтий аймгийн Аудитын Газар болон Ай Жэй Эй Эйч Аудит ХХК-д хүргүүлнэ үү.



**Асуудал 1: Үндсэн хөрөнгийн талаар****Тэргүүлэх ач холбогдол №1****АГ-ын ажиглалт**

Зохих байгууллагын зөвшөөрөлгүйгээр 4,532.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг хичээл үйлдвэрлэлийн зардал болон урсгал засварын зардлаас худалдан авч бэлтгэсэн нь Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн холбогдох заалтуудыг зөрчиж байна.

**АГ-ын зөвлөмж**

Цаашид урсгал засварын зардлаас хөрөнгө бэлтгэдэг явдлыг таслан зогсоохыг зөвлөж байна.

**Эрсдлүүд**

Санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, толилуулга ба тодруулга, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байх эрсдэлтэй.

**Төсвийн захирагчийн хариу**

Аудитын асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтнуудад танилцуулж, албан бичгээр баталгаажуулсан болно.



**Асуудал 2: Зардал хооронд шилжүүлж зарцуулсан талаар**

**Тэргүүлэх ач холбогдол №1**

**АГ-ын ажиглалт**

Түлш халаалтын зардлаас 62.6 мянган төгрөгийг шатахуунд, үдийн цайны зардлаас 66.2 мянган төгрөгийг хичээл үйлдвэрлэлийн зардалд бүртгэсэн байгаа нь Сангийн сайдын 2013 оны 73 тоот тушаалын 5 дугаар зүйлийн 5.4 т Төсвийн байгууллага зардлын бүлгийн дүнд багтаан эдийн засгийн ангилалын дагуу зардал гаргахыг зөрчиж байна.

**АГ-ын зөвлөмж**

Цаашид анхан шатны баримтыг үндэслэн зардлын эдийн засгийн ангилалыг үнэн зөв бүртгэхийг зөвлөж байна.

**Эрсдлүүд**

Санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, оршин байх, тохиолдсон байх, хэмжилт, толилуулга ба тодруулга, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байх эрсдэлтэй.

**Төсвийн захирагчийн хариу**

Аудитын асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтнуудад танилцуулж, албан тоотоор хариу авч баталгаажуулсан болно.



**Асуудал 3: Үндсэн хөрөнгийн элэгдлийн тооцоо**

**Тэргүүлэх ач холбогдол №1**

**АГ-ын ажиглалт**

Тайлант хугацаанд үндсэн хөрөнгөнд элэгдэл тооцохдоо байгууллагын НБББББ-т зааснаар Засгийн газрын 233-р тогтоолоор баталсан журамд заасан хугацааг баримталсан байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах"; Үндсэн хөрөнгийн элэгдлийн талаар УСНББОУС 17-гийн 90-д заасныг мөрдөж ажиллахыг зөрчиж байна.

**АГ-ын зөвлөмж**

Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох хугацааг Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болон санхүүгийн програмд өөрчлөлт оруулж мөрдөх, Үндсэн хөрөнгийн элэгдлийн талаар

**Эрсдлүүд**

Санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, хэмжилт, толилуулга ба тодруулга, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байх эрсдэлтэй.

**Төсвийн захирагчийн хариу**

Аудитын асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтнуудад танилцуулж, албан тоотоор хариу авч баталгаажуулсан болно.



**Асуудал 1: Санхүүгийн байдлын тайлангийн талаар**

**Тэргүүлэх ач холбогдол №2**

**АГ-ын ажиглалт**

Тус байгууллагын санхүүгийн байдлын тайлангийн бараа материалын дансдын ангилал, бараа материалын тодруулга хэсгийн дансдын ангилал хоорондоо зөрүүтэй ангилалыг буруу бүртгэсэн, ойлгомжгүй байгаа нь Сангийн сайдын 2014 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 05 тоот тушаалын 5 дугаар хавсралтаар баталсан балансын дансны жагсаалтыг мөрдөж ажиллаагүй байна.

**АГ-ын зөвлөмж**

Цаашид холбогдох дүрэм журмыг мөрдөж санхүүгийн тайлан хэрэглэгчдийг үнэн зөв мэдээллээр хангах.

**Эрсдлүүд**

Санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, хэмжилт, толилуулга ба тодруулга, оршин байх, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байх, хууль тогтоомж, заавар журам хэрэгжихгүй байх эрсдэлтэй

**Төсвийн захирагчийн хариу**

Аудитын асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтнуудад танилцуулж, албан бичгээр баталгаажуулсан болно.



**АГ-ын ажиглалт**

Тайлант хугацаанд харилцагчидтай үүссэн өглөг авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулахгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн Ерөнхий нягтлан бодогчийн эрх үүргийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулах, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах, 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

**АГ-ын зөвлөмж**

Нягтлан бодох бүртгэлийн хуулийг дахин судлах, харилцагч эд хариуцагчтай тооцоо, тооллогыг хугацаанд нь хийж тооцоо бодсон актаар баталгаажуулж хэвших.

**Эрсдлүүд**

Санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, хэмжилт, толилуулга ба тодруулга, оршин байх, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байх, хууль тогтомж, заавар журам хэрэгжихгүй байх эрсдэлтэй.

**Төсвийн захирагчийн хариу**


Аудитын асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтнуудад танилцуулж, албан тоотоор баталгаажуулсан болно.



**МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ**

**ХЯНАСАН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР



Ч.ЭРДЭНЭБААТАР  
Д.ОЮУНТУЯА

Огноо: *2018.2.28*

Огноо: *2018.2.28*

**БЭЛТГЭСЭН:**

АУДИТОР



Н.УРАНЧИМЭГ Огноо: 2018.02.24